



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 11 сарын 12 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тухай хуулийн 269¹ дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 269¹.1.11 дэх заалт нэмсүгэй:

“269¹.1.11.улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх.”

2 дугаар зүйл. Гаалийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“60.3.4.хуульд заасан бичиг баримт;”

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР